



ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ-ЫН ГИШҮҮДЭД

ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

2024.01 сар

Мэндгиллээ

Иргэний Зориг Ногоон нам нь ардчилал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлсэн, ногоон хөгжлийг тэргүүлэх бодлогоо болгон хэрэгжүүлж ирсэн, улс төрийн намуудаас дөрөвдүгээрт жагсдаг Монголын ууган намын нэг билээ.

ИЗНН байгуулагдсан цагаасаа үйл хэрэг, үзэл бодолдоо тууштай шударга хандаж, Монгол Улсынхаа хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулж ирсэн бөгөөд үндэснийхээ эрх ашгийн төлөө ажиллаж ирснийг өнгөрсөн 24 жилийн түүх харуулна.

Намын гишүүд дэмжигчдийнхээ итгэлийг хэзээд алдаагүй ИЗНН нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг баримтлан, улс төрийн ямарваа нэгэн бүлэглэл, фракцид хамааралгүй явж ирсэн бөгөөд эдийн засгийн болоод улс төрийн бие даасан хараат бус үйл ажиллагааг явуулсаар ирсэн.

ИЗНН авлигатай тууштай тэмцэж, ард түмнээс хууль бусаар булаасан баялгийг авлигачдаас эргүүлэн авахын төлөө, Эрх чөлөөний хуулийг санаачлан Монгол Улсын иргэн бүрийн эрх чөлөөг тунхаглан хамгаалахын төлөө, байгаль орчинд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байна.

Хүн бүрт эрх чөлөө, шударга байдал, эх оронд минь хөгжил цэцэглэлт ирэх болтугай.

ИЗНН-ын дарга  Батын Батбаатар

ИЗНН-ЫН X ИХ ХУРАЛ БОЛОВ



саналаар Б.Батбаатарыг намын даргаар сонголоо. 2023 оны зургадугаар сард тус намын даргаар ажиллаж байсан УИХ, Засгийн газрын гишүүн асан, ИЗНН-ын дарга Ц.Ганхуяг өөрийн хүсэлтээр ажлаа өгсөн тул тус намын дэд даргаар ажиллаж байсан УИХ-ын гишүүн асан Б.Батбаатарыг олонхийн саналаар сонгосон юм.

Мөн хурлаар ирэх оны сонгууль болон улс төрийн нөхцөл байдлыг дүгнэж, гол зорилго, чиглэлээ тодорхойллоо.

ИЗНН-ын X Их хурал 2023 оны есдүгээр сарын 09-ний өдөр болов. Хуралд 21 аймаг, есөн дүүргээс 288 төлөөлөгч оролцов.

Хурлаар ИЗНН улс төрийн хүчний хувьд цаашид ямар байр суурь, бодлоготой байх, дүрэмд өөрчлөлт оруулах тухай болон намын даргаа батламжлах гэх мэт хэд хэдэн асуудлыг хэлэлцэв. Хурлаар нийт гишүүдийн 93.7 хувийн



ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

- ЭР ЗОРИГ
- ЭРХ ЧӨЛӨӨ

- НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ
- УЛАМЖЛАЛ
- ТУСГААР ТОГТНОЛ

Үндэсний хороо хуралдаж, дүрмээ өөрчлөн батлав

ИЗНН-ын Үндэсний хорооны хурал 2023 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хуралдаж, олон асуудал хэлэлцлээ. Тус хурлаар хэлэлцсэн гол асуудал нь дүрмийн өөрчлөлт байв. Дүрэмд нэлээд өөрчлөлт орсон бөгөөд хэд хэдэн чухал заалтууд нэмэгдэж, зарим заалт өөрчлөгдсөн юм. Анхаарал татсан өөрчлөлтийн нэг нь бүтцийн өөрчлөлт байлаа. Шинэ дүрмээр дунд шатны байнгын ажиллагаатай намын байгууллагууд бий болжээ. Мөн намын дэргэдэх байгууллагууд ямар байх талаар дүрэмд тусгасан бөгөөд ИЗНН олон түмний нам байх боломжийг нээж өгсөн байна.

Жишгээр бол намуудын дэргэдэх байгууллага нь эмэгтэйчүүд, залуус, ахмад, оюутны холбоо байж болохыг тусгасан байдаг. ИЗНН-ын хувьд намын дэргэд клуб, хөдөлгөөн, иргэний нийгмийн байгууллагууд, лобби бүлэг, мэргэжлийн холбоод байж болно гэж нэлээд өргөн хүрээг хамруулан тусгасан нь анхаарал татаж байна. Холбоод хуралдан удирдлага сонгох бөгөөд тухайн хүн ИЗНН-ын улс төрийн шийдвэр гаргах Үндэсний хороонд орох боломжийг нээж өгч байгаа юм.

Батын БАТБААТАР: ИЗНН сөрөг хүчин байх болно



ИЗНН-ын дарга Батын Батбаатартай ярилцлаа.

-ИЗНН хэсэг нам гүм болсон. Сүүлийн үед танай намын үйл ажиллагаа эрчимжиж, бүтцийн болон бодлогын өөрчлөлтүүд хийгдэж байна. Тэр өөрчлөлт, шинэчлэлтүүдээс ярилцлагаа эхэллээ?

-ИЗНН бол түүхтэй нам. Монгол Улсад бүтээсэн зүйлтэй нам. ИЗНН сүүлийн 7, 8 жил таны хэлсэн шиг үйл ажиллагаа нь доголдсон байсан. Намын гишүүд, дэмжигчид ард иргэдээсээ уучлалт хүсч байна. Одоо ИЗНН дахин төрсөнтэй адилхан, шинэчлэгдэн зохион байгуулагдаж шинэ өөрчлөлтийг дотооддоо хийж гарч ирж байна. 2023 оны зургаа, найм, есдүгээр сард намын Их хурал хуралдаж намын шинэ удирдлагаа сонгосон. Мөн 12 дугаар сард нам хуралдаад дүрмийн өөрчлөлтөө хийлээ. Энэ дүрмийн өөрчлөлтөөр ИЗНН олон түмний нам байх тэр боломжийг нээлээ. ИЗНН бусад намаас

ялгагдах онцлог нь олон түмний нам байна, ард түмний тайз нь байна гэдгээ дүрмэндээ суулгаж чадсан. Тухайлбал, бусад намуудын хувьд намын дэргэдэх байгууллагуудын тухай тусгахдаа ахмад, залуучууд, эмэгтэйчүүд, оюутны холбоо, эсвэл бодлогын хүрээлэн, институц ч юм уу байгуулах тухай л заасан байдаг. Харин ИЗНН бол "Намын дэргэд хөдөлгөөн, клуб, лобби бүлэг, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод байж болно" гэж тусгасан. Ийм чухал ач холбогдолтой өөрчлөлт орсон. Мэргэжлийн холбоод гэдэг нь уурхайчид, малчид, мэс заслын эмч нар ч юм уу, мэргэжил сонирхлоороо нэгдээд зохион байгуулалтад орж, санал санаачилга гаргаад намын дэргэдэх байгууллагыг байгуулвал тэр салбар мэргэжлийн хүмүүсийн байгуулсан холбоо, клуб, иргэний байгууллагуудынх нь удирдлага ИЗНН-ын улс төрийн шийдвэр гаргах Үндэсний хороонд орох боломжийг нээж өгч байгаа юм.

Төгсгөл нь III нүүрт

НАМЫН ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУД ХУРАЛДЛАА

- 2023 оны 9 дүгээр сарын 2-5-ны өдөр -

ИЗНН-ын дэргэдэх Эмэгтэйчүүд, Залуучууд, Ахмадын байгууллага болон оюутнуудын холбооны хурлыг тус тус зохион байгуулав. Энэ үеэр хурлын төлөөлөгч, үндэсний хорооны гишүүдийг батламжлав.



ДҮҮРГИЙН НАМЫН ХОРООНЫ ДАРГА НАРЫГ БАТЛАМЖЛАВ

ИЗНН-ын Улс төрийн зөвлөлийн хурал нэгдүгээр сарын 18-ны өдөр боллоо. ИЗНН-ын дүрмийн 11.4, 28.1.9 дэх заалт, дүүргийн намын хороодын хурлын тэмдэглэл, тогтоолуудыг үндэслэн ИЗНН-ын дарга Б.Батбаатар Нийслэлийн зургаан дүүргийн намын хорооны даргыг батламжлав.



ИЗНН-ын удирдлагууд намын гишүүдийн итгэлийг хүлээж, сонгогдсон Баянгол дүүргийн намын хорооны дарга Г.Ууганхүү, Баянзүрх дүүрэг Н.Эрхэмбаяр, Сонгинохайрхан

дүүрэг Г.Роза, Сүхбаатар дүүрэг Ч.Мөнхжаргал, Хан-Уул дүүрэг Я.Пүрэвгарьд, Чингэлтэй дүүргийн Намын хорооны дарга С.Хан-Уул нарт баяр хүргэж, ажлын амжилт хүслээ.



• МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ:

Дээд шүүх ИЗНН-ын даргаар Б.Батбаатарыг бүртгэлээ

Иргэний Зориг Ногоон нам өнгөрсөн есдүгээр сард Их хурлаа хийж намын даргаараа УИХ-ын гишүүн асан Батын Батбаатарыг сонгосон. Хуулийн дагуу шинээр сонгогдсон намын даргаар бүртгүүлэхээр Дээд шүүхэд ханджээ. Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны аравдугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар ИЗНН-ын даргаар Б.Батбаатарыг бүртгүүлэхээр тус намаас ирүүлсэн өргөдлийг хэлэлцээд холбогдох хууль болон тус намын дүрэмд нийцсэн гэж үзэж бүртгэхээр шийдвэрлэлээ.

Үндэсний хорооны хурлаар генсек, дэд дарга нарыг томилов



ИЗНН-ын Үндэсний хорооны 2023 оны арванхоёрдугаар сарын 9-ний өдрийн хурлаар намын дүрмэндээ өөрчлөлт оруулж, удирдлагын бүтэц өөрчлөлт, шинэчлэл хийлээ. Намын дүрмийн өөрчлөлттэй холбоотойгоор намын удирдлагын бүтэц өөрчлөгдөж, ИЗНН тэргүүн дэд даргатай болж, намын дэд дарга болон Ерөнхий нарийн бичгийн дарга нараа сонголоо. Тус намын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан С.Батбаатар тэргүүн дэд даргаар сонгогдож, намын ерөнхий нарийн бичгийн даргаар Р.Батболд сонгогдсон бол Л.Ганхуяг Т.Чинбат З.Болдбаатар нар дэд даргаар тус тус сонгогдов.

Намын анхан, дунд шатны байгууллагууд хуралдаж байна

ИЗНН Х Их хурлаа хийснээс хойш намын үйл ажиллагаа нь идэвхжих болсон. Намын бүх шатны гишүүдээ бүртгэлжүүлж, намын үйл ажиллагаанд оролцох идэвхийг нэмэгдүүлэх шатлалтай ажлыг хийж байна. Өнгөрсөн арванхоёрдугаар сараас эхлэн Нийслэл дүүргийн ИЗНН-ын хороо хуралдаж эхэлсэн. Тухайлбал, Баянзүрх дүүргийн намын хорооны хурал болж намын дүрмийн шинэчлэлтэй холбоотойгоор гишүүдээ мэдээлэл хүргэжээ. Намын дүрмэнд орсон өөрчлөлтүүд, бүтэц зохион байгуулалт хэрхэн өөрчлөгдсөн талаар зөвлөгөө мэдээллийг намын даргын ахлах зөвлөх Т.Бат-Эрдэнэ өгсөн байна. Энэ үеэр тус намын хороонд шинээр 22 гишүүн элсчээ.

Мөн энэ оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Сүхбаатар дүүргийн намын хорооны хурал болжээ. Хурлаар дүүргийн намын хороодыг идэвхжүүлэх, ирж буй сонгуульд хэрхэн оролцох, намын гишүүнчлэлээр бүртгэх гэх мэт хэд хэдэн асуудал хэлэлцсэн байна. Энэ үеэр дүүргийн намын хорооны гишүүдийн санал хураалтаар Сүхбаатар дүүргийн Намын хорооны даргаар Ч.Мөнхжаргалыг сонгожээ.

Одоогийн байдлаар Сүхбаатар, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол гэсэн зургаан дүүргийн намын хурал болоод байгаа юм. Дүүргийн намуудын хорооны хурлын үеэр ИЗНН-д шинээр гишүүд элсэн орж, үйл ажиллагааг дэмжин ажиллахаа илэрхийлжээ байв. Ийнхүү Нийслэлд ИЗНН-ын анхан болон дунд шатны намын хорооны хурлууд болж, үйл ажиллагаа нь өдрөөс өдөрт идэвхжиж байгаа бол хөдөө орон нутаг руу чиглэсэн намын дотоод хурлуудыг удахгүй хийхээр төлөвлөжээ.

Төрийн шагналт зураач Ц.Энхжин ИЗНН-д элслээ

ИЗНН-д шинээр намын гишүүд элсэж байна. Баянгол дүүргийн намын хорооны гишүүнээр төрийн шагналт зураач Ц.Энхжин элслээ. Төрийн шагналт зураач Ц.Энхжин хэлэхдээ "ИЗНН бол ардчиллын нам. Өдгөө 24 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Ардчиллын үндэс суурийг тавихад оролцсон ИЗНН бол ардчиллын анхдагчдын нэг болох С.Зориг агсантай гүн нягт холбоотой. Энэ нам бол Монголын нүүдэлчдийн үзэл санааг тээгч, эх байгалиа дээдлэх үзэл санаатай. Энэ нь Монгол Улсын цаашдын хөгжилд дорвитой хувь нэмэр оруулна гэдэгт би итгэлтэй байдаг" гэв.



Түрүүч нь 1-р нүүрт

Мэргэшсэн Засгийн газрыг Монголын ард түмэн шаардаад байдаг. Мэргэшсэн Засгийн газар байгуулж байна гэж хэлээд байдаг. Тэгсэн хэрнээ мэргэшсэн Засгийг газрыг УИХ байгуулж чадахгүй байна. Засаг захиргааны нэгжээс тусдаа салбар, салбарын тэргүүлэгчид намын улс төрийн шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцдог энэ боломжийг бүрдүүлснээрээ ИЗНН олон түмний нам болж чадаж байгаа юм.

-Сайд нар заавал мэргэжлийн хүмүүс байх ёстой биш, бодлогын хүн л байхад болно гэж зарим нь ярьдаг. Тэрэн шиг заавал мэргэжлийн хүмүүс байх ёстой гэж хэлээд байна уу?

-Мэргэжлийн Засгийн газар гэдэг өөрийн чинь хэлж байгаатай адил тухайн мэргэжлийн хүн тэр салбарыг удирдана гэдэг утгаар биш юм. Тухайн салбарын мэргэжилтнүүдээр бодлогыг нь гаргуулж чаддаг байх нь мэргэжлийн Засгийн газар байна гэдэг ойлголт. Өнөөдөр хэн нэгэн сайд болоод 10 жилийн ангийн хүүхэд, хамаатан садан, өөрийгөө тойрдог хүмүүс дотроос тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдөөгүй хүнийг өөрийн зөвлөхөө болгож аваад нэг зүйл шинээр сэдэж хийгээд эхэлдэг нь мэргэжлийн бус болгочихоод байгаа юм. Нэг ёсондоо улстөрчид салбарын сайдаар ажиллаж, бодлого зангидахыг буруутгах зүйлгүй.

Харин улстөрчид салбараа мэдэхгүй, гэнэт цоо шинэ бодлого зохиогоод яваад байж болохгүй. Үнэхээр сайн эмч, сайн салбарын мэргэжилтэн юм уу, сайн малчин байлаа гэхэд ийм хүмүүс намын удирдлагад орох боломж нь хаалттай. Тухайн аймаг дүүргээсээ сонгогдоод намын эрх барих дээд байгууллагадаа ороход аймаг дүүргийнхээ намын нэгжээр дамжаад ирэхээр тэнд салбарын биш дунд шатны намын удирдлагууд нь гарч ирээд байдаг. Тэд нар нь салбарын хүмүүс биш байгаад байдаг. Ийм хүмүүс төв дээрээ ирэхээрээ бүгдээрээ бодлогын хүмүүс буюу улстөрчид болоод хувирчихдаг. Салбарын мэргэжилтэн шийдвэр гаргадаг Үндэсний бодлогын хороо, Бага хурал дээрээ орж ирэх боломж бага байдаг. Манай намын хувьд улс төрийн буюу намын байгууллагуудын босго шүүлтүүр, сонголтоос үл хамаараад тухайн салбарын мэргэжилтнүүд эмч, багш, сувилагч нар нийлж суугаад хуралдаад байгууллага байгуулахад, тэндээсээ сонгогдсон хүн ИЗНН-ын улс төрийн бодлого шийдвэр гаргадаг эрх барих байгууллагад орно.

“Ард түмний тайз байна” гэж танай намынхны хэлээд байгаа нь иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, өөрсдөө орох үүд хаалгыг нээх, санаа оноогоо шийдвэрт тусгуулах боломж байгааг хэлээд байна гэж ойлголоо.

-Тийм, тийм.
- Нэг үе Уламжлалын нэгдсэн нам гуравдагч хүчний байр суурь гэж их ярьдаг байсан. Сүүлийн үед ХҮН гуравдагч хүчний байр суурь гэж ярих болж. ИЗНН-ын хувьд ууган намын нэг. ИЗНН улс төрийн гуравдагч хүчин гэдэг ойлголт дээр ямар байр суурьтай байдаг вэ?

-ИЗНН гуравдагч хүчин гэдэг ойлголтыг сүүлд болсон хурлаараа авч хаясан. ИЗНН Монголын ард түмэнтэйгээ хамт сөрөг хүчний үүрэг гүйцэтгэнэ гэж өөрийнхөө улс төрийн зорилтоо тодорхойлсон. Тиймээс ИЗНН сөрөг хүчний байр суурь дээр гарч ажиллах болно.
-Сөрөг хүчин болно гэхээр хүн хүч, хөрөнгө мөнгө гээд олон бэрхшээл тулгарах байх. Ямар үндэслэлээр сөрөг хүчин болох зорилт тавьж байгаа вэ?

-УИХ-ын сонгууль болно. Энэ сонгуулиар өөрчлөлт орно. Тийм болохоор энэ хүртэл ИЗНН сөрөг хүчний байр суурийг баримталж ажиллана. Эрх баригч намын байр сууринаас биш, гуравдагч хүчний талаас биш, Монголын ард түмэнд ус агаар мэт хэрэгтэй байгаа сөрөг хүчний байр сууринаас улс төрийн шийдвэр бодлогуудаа гаргана гэж ойлгож болно.

-Одоо байгаа сөрөг хүчнийг хангалтгүй гэж үзэж байна уу?

-Одоо сөрөг хүчин байхгүй. Сөрөг хүчнийг хангалттай, хангалтгүй гэж дүгнэх боломжгүй. Өнөөдөр УИХ-д суудалтай гурван нам байна. Эрх барьж байгаа нэг нам нь байна. Цөөнх нь сөрөг хүчний үүрэг гүйцэтгэж чадахгүй байгаа. Тиймээс Монголд сөрөг хүчин гэж байхгүй. Яг үнэндээ эрх баригч нам өөрөө өөрсдөө сөрөг хүчний үүрэг гүйцэтгэж байгаа.

-ИЗНН гэхээр ногоон бодлоготой нам гэж шууд буудаг. Танай гол бодлого ямар чиг шугамтай байх юм бэ?

-Бид ногоон бодлогыг ногоон амьдрал гэж энгийнээр томъёолж байгаа. Нэг ёсондоо

Батын БАТБААТАР: ИЗНН сөрөг хүчин байх болно



ногоон соёл иргэншил гэдэг тэр хэмжээнд нь авч үзэх хэрэгтэй. Байгаль орчныг хамгаалах гэдэг юм уу цаашлаад ногоон хэрэглээ, ногоон эдийн засаг, ногоон хөгжил гэж өмнө нь явсан бол одоо ногоон соёл иргэншлийн түвшинд нь авчрах хэрэгтэй. Ногоон амьдрал дунд амьдарсан, байгаль дэлхийтэйгээ харилцан хамааралтайгаар байгальдаа зохицон амьдарсан ард түмэн дэлхий дээр тийм олон байхгүй. Хамгийн сайн тохирч амьдарсан улс үндэстэн гэвэл Монгол эхэнд нь нэрлэгдэнэ. Дээрээс нь ногоон соёл иргэншлийг Монгол Улсын голлох бодлого болгож хувиргахын төлөө ажиллана. Бид нар тодорхой үйлдвэрлэлээр, өрсөлдөх чанарын хувьд, зах зээлийн орон зайн хувьд, эдийн засаг, хүний нөөцийн хувьд боломж хязгаарлагдмал. Бид хичнээн хичээгээд ч дэлхийн улс гүрнүүдээс эхэнд нь гарч ирнэ гэхэд маш хүнд. Харин ногоон соёл иргэншлийг зөв зүйтэй бодлогоор гаргаж ирвэл цөмийн зэвсэггүй бүс гэдэг шиг Монголыг дэлхийд гаргах тэр гүүр нь ИЗНН байж чадна гэдэг томъёолол дээр ногоон бодлого боловсруулж байгаа юм.

-Намуудын ард талд нь эзэн байна гэх яриа яваад байдаг. Танайх ч хардлага сэрлэгэд өртөөд хариу мэдэгдэл гаргаж байсан...

-Тийм тоглоомыг ИЗНН-ын дотоодод яасан ч оруулж ирэхгүй. Тэр тухай манай гишүүд, дэмжигчид санаа зовохгүй байж болно. ИЗНН эр, ир зоригийг ИЗНН гаргах болно. Энэ өөрөө олон түмний, ард түмний тайз байх нөхцөлийг бүрдүүлж байгаа. Дээрээс нь ард түмний тайз бол хэзээд эзэн нь нэг л байгаа. Тэр нь Монголын ард түмэн. Манай намын ард удирддаг нууц ноёнтон гэж ярьдаг ямар нэг хүн байх боломжгүй. ИЗНН хэн нэгний

хаммааралтай байх боломжгүй. Үүнийг огтхон ч хүлээн зөвшөөрөхгүй. Монголын улс төрийн намууд үүргээ гүйцэтгэж чадахаа больчихсон. Бүгдээрээ эрх баригчид юм уу тодорхой улстөрчид бизнесийн бүлгийнхний найруулан тавьж байгаа жүжигт нь олны хэсэгт нь тоглодог болчихсон. Туслах дүр бүтээдэг. Туслах дүр бүтээсэн нь гол дүрээ товойлгож гаргаж ирдэг ажил хийгээд байгаа юм. Тэр замаар манай нам яасан ч явахгүй.

-Танай намын бүтэц бүрэлдэхүүн нэлээд өөрчлөгдчихлөө. Фракц бүлэглэлийг юу гэж үздэг вэ. Зарим нам олон фракцтай байгаагаа эрүүл үзэгдэл гэж үзэх нь бий. Эвтэй байна гэдгийг юу гэж үздэг юм?

-Ярихдаа тунхаглалын чанартай гоё зүйл ярьдаг хэрнээ кноп дарж бид энэ орон зайг нь авах зорилгоор зохион байгуулагддагаа эрүүл үзэгдэл гэж хэлэх нь хошин шогоос ялгаагүй. Манай намд өнөөдрийн байдлаар тийм зүйл алга. Энэ нам бол хэн нэгэн хүнийг ажилтай, албан тушаалтай болгоход зориулагдаж үйл ажиллагаа явуулдаг нам биш ээ. Монголдоо сайхан амьдрах тэр боломжийн төлөө, боломжийг бүрдүүлэхийн төлөө ажиллаж амьдарч байгаа. Эв нэгдлийн тухайд үг нь ард түмнээрээ нэг тийш харах гэдэгтэй адилхан юм. ИЗНН-ын гишүүд өнөөдрийн байдлаар бүгдээрээ нэг зүгт харчихсан байна. ИЗНН-ынхан Монгол Улсын төлөө, шударга ёсны төлөө, авлигагүй нийгмийн төлөө, эрх чөлөөний төлөө бүгд нэг тийшээ харж чадаж байна гэж намын даргын хувьд харж байгаа.

-Гишүүнчлэлийн хувьд?

-ИЗНН зовлон туулсан нам. Энэ нам нийгмийн шударга ёс алдагдсан хүнд нөхцөл байдалд шударга ёсыг хүсэж төрж гарсан нам. Төрсөн түүх нь тийм юм. Төрснөөсөө хойш өнөөдрийг хүртэл зовлон туулсан. Байнга

л хоёр том улс төрийн хүчинд хавчигдаж ирсэн. Монголд Авлигын эсрэг хуулийн төслийг анх санаачилсан нам. Гурван А буюу архидалт, авлигал, ажилгүйдлийн эсрэг бодлогоо тодорхойлж байсан. Бүтээлч баян чинээлэг монголчуудыг бүтээн гэж гарч ирж байсан нам. Атрын гуравдугаар аян ИЗНН-ын санаачилгаар анх бий болж байсан. ИЗНН бол эрүүл улс төрийн хүчин болно. ИЗНН жин дарж байгаа намуудаас гадна бусад улс төрийн намууд шиг өмчлөгдөөгүй нам. Компаничлагдаагүй нам. Харьцангуй бие даасан эрүүл тодорхой зорилготой оюунлаг гэгээн нам юм аа. Олон түмний нам байж болох тэр бүх боломжийг бий болгосон. Манай намд гаднаас даалгавар байхгүй. Даалгавар өгөх гэсэн оролдлого газар дээрээ тас цохигдоно. Тийм учраас эрүүл хүмүүс цуглаж, улс орныхоо төлөө зүтгэх боломж манай намд байна гэж харж байгаа.

-Ногоон соёл иргэншлийн төлөө гэхээсээ илүү өдрийнхөө хоолыг яана гэж байна гэх байр суурьтай хүмүүс байх вий гэж бодож байна...

-Соёл иргэншил гэдгийг хол зайтай үгээр нь авч сонсоод байх шиг байгаа юм. Монголчууд 3000 жил төрт улстай байсан. Энэ түүхэн хугацааг аваад үзэх юм бол дандаа л Монголын соёл иргэншил нүүдлийн соёл иргэншил гэж байсан. Үүнтэй адилхан. Нүүдлийн соёл иргэншлийг ногоон соёл иргэншил гэж авч үзэхэд болно. Үндсэн соёл иргэншил маань л юм. Язгуурынх нь хувьд дээш нь гаргаж ирье гэсэн асуудал байгаа юм. Нүүгээд явахдаа хог үлдээгээд явдаггүй чинь л ногоон соёл иргэншил юм. Энэ нь амьдралаас их хол зүйл биш. Монголын ард түмэн энэ зүйлээсээ холдчихоод байгаа юм. Тээж явсан суурь соёл иргэншлээ буцаагаад олж авъя аа л гэж байгаа юм.

Д.ХҮСЛЭН

3.БОЛДБААТАР: Ногоон бодлогыг хэрэгжүүлэхэд ИЗНН тэргүүлэн ажиллана

ИЗНН-ын Нийслэлийн намын дарга З.Болдбаатартай ярилцлаа.

-Нийслэл, дүүргийн намын хороод саяхан хуралдлаа. Намын дүрэм, бүтцэд ямар шинэ өөрчлөлтүүд оров?

-Манай нам Их хурал, Үндэсний хорооны хурлаа хийлээ. Намын дүрмэндээ шинэчлэлт хийлээ. Нийслэлийн дүүргүүд дүрмийн шинэчлэлийн дагуу хурлаа амжилттай зохион байгууллаа. Намын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаанд олон шинэчлэлт өөрчлөлтүүд орж байна. Үндэсний хорооны гишүүд шинэчлэгдлээ. Улс төрийн зөвлөлийн гишүүдээ батлах, Нийслэлийн намын хорооны Тэргүүлэгчдийг батлах гэх бүтэц зохион байгуулалтын ажлууд дүрмийн дагуу явагдаж байна. Нийслэлийн хэмжээнд дүүргүүд хурлаа амжилттай зохион байгуулсны дагуу дүүргийн намын хорооны дарга нарыг намын удирдлага саяхан батламжиллаа.

-Танай нам шинэ даргатай болж, үйл ажиллагаа нь идэвхжих болсон. Шинэ удирдлагын баг юу хийх вэ. Дотоод зохион байгуулалтаа цэгцэлж амжсан уу?

-Сүүлийн нэг, хоёр жилээс намын үйл ажиллагаа буцаж сэргэсэн. Нийслэлийн хувьд одоо дотоод зохион байгуулалт, бүтцийг маш сайн хийж байгаатай холбоотойгоор намын өдөр тутмын үйл ажиллагаа улам идэвхжиж, үйл ажиллагаа өргөжин намын бодлогыг хэрэгжүүлэх ажлууд руугаа орж байна. Манай намын дотоод зохион байгуулалт цэгцэрсэн гэж хэлж болно. Намын дүрмийн шинэчлэлттэй холбоотой Нийслэлд бүтэц, зохион байгуулалт цэгцэрсэн. Намын удирдлагын баг одоо орон нутгийн намын хороод руугаа ажиллаж эхэлж байна. Орон нутаг руу бүсчилсэн байдлаар явах, намын сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Зарим нэг аймагт намын байртай болгох гэх мэт шийдвэрлэх асуудлууд бий.

-Намын гишүүд рүүгээ хандсан ямар ажлууд хийх вэ?

-Бүх дүүргийн намын даргаа томилж, шинэ дүрмийн дагуу



ажиллаж байгаа гэж дээр хэлсэн. Төв намын бодлогыг хэрэгжүүлэх, анхан, дунд шатны байгууллагуудын чадавхийг сайжруулах сургалт семинар зохион байгуулж байна. Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль тогтоомжийг намын гишүүддээ таниулах, сургалт хийнэ.

-Танай намд боловсон хүчин хэр байна вэ. Шинэ хуулиар хүчийн тэгш байдлын асуудал нэлээд сайн тусгагдсан. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд ямар бодлого барих вэ?

-ИЗНН бол жендерийн тэгш байдлыг хангуулах заалтыг намынхаа дүрэмд оруулсан анхны намын нэг. Хүйсийн тэгш байдлыг хангах асуудлыг анх гаргаж тавьсан нам. Тиймээс ч энэ тал дээр туршлагатай нам. Нөгөөтэйгүүр манай нам боловсон хүчин сайтай. Гишүүд дээрээ суурилсан нам.

Түүнчлэн ногоон хөгжил, байгальд ээлтэй үзэл баримтлалыг УИХ-аар хэлэлцүүлж, Ногоон хөгжлийн бодлогыг батлуулж байсан намын хувьд дэлхий нийтийн өмнө тулгамдаад буй байгаль орчныг сэргээх, ногоон соёл иргэншлийг дэлгэрүүлэх үйлсэд ИЗНН Монгол Улсдаа тэргүүлэн ажиллах үүрэг, хариуцлага бидэнд ирлээ гэж ойлгож байгаа.

-Ногоон хөгжилд ямар бодлого баримтлах вэ?

-Дэлхий нийтэд байгаль орчныг хамгаалах асуудал нь нэг улс орны үйл хэрэг биш болоод байгаа. Манай нам үзэл

баримтлалын хувьд ногоон хөгжлийг түүчээлж ирсний хувьд ногоон соёл ахуйтай байсан монголчуудынхаа тэр өв соёлыг сэргээх, ногоон соёл иргэншлийн төлөө ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа. Монгол Улсын хөгжлийн бодлогод өөрчлөлт оруулах замаар ногоон хөгжлийн бодлогын зорилтуудтай салбарын бодлогыг уялдуулан, ногоон эдийн засагт шилжих, ногоон соёл иргэншлийг нэвтрүүлэх, бусад улс орнуудад үлгэр болохуйц сайн туршлагыг бий болгож чадах чадамж байна гэж харж байна.

ИЗНН нь Монгол Улсад ногоон хөгжлийн үндэс суурийг тавихад үнэтэй хувь нэмэр оруулсан төдийгүй Монгол Улсад хийж хэрэгжүүлсэн бодлого нь өнөөг хүртэл улам боловсронгуй болон хэрэгждэг. Парламентад 16 жил суудалтай байсан тус нам хэсэгхэн хугацаанд үйл ажиллагаа нь суларч байсан ч буцаад үйл ажиллагаа нь шинэчлэгдэж сэргэсэн. Намын шинэ даргатай болж, намын шинэчлэлийн бодлогыг явуулж, өмнөх амжилтаа ахиулах замаар улс эх орныхоо хөгжлийн төлөө бид ажиллах болно. Бид "ард түмний нам байна" гэдгээ зарласан. Улс орны сайн сайхны төлөө, байгаль орчин, тогтвортой байдал, эрүүл аюулгүй нийгмийн төлөө, шударга хуваарилалт, хуулийн хэрэгжилтийг сахиулах эдгээр зорилгуудаа хэрэгжүүлэхийн төлөө намын шинэчлэлийн бодлогоо амжилттай хийж ажиллаж байна.

Б.ЭРДЭНЭ

• МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ:

ИЗНН: Хөрөнгө оруулалтын тухай хуульд байр сууриа илэрхийлэв



ИЗНН-аас цаг үеийн асуудлаар 2023.01.12-ны өдөр "MN25" хэвлэлийн төвд хэвлэлийн бага хурал хийв. УИХ-ын чуулганаар хэлэлцэж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан ИЗНН-ын дарга Б.Батбаатар, тус намын даргын эдийн засгийн зөвлөх Д.Амгалан, Т.Чинбат нар дараах байр суурь илэрхийлсэн.

ИЗНН-ын даргын эдийн засгийн зөвлөх доктор Д.Амгалан хэлэхдээ: "Хөрөнгө оруулалтын тухай хууль нь эдийн засагт ирэх үр өгөөж, ард түмний амьжиргаанд нөлөөлөх нөлөөлөл, хөрөнгө оруулалтын давуу талыг танилцуулах нь гол асуудал байсан. Түүнээс биш нийгмийг талцуулж, улстөржүүлдэг сэдэв биш. Хөрөнгө оруулалттай шууд хамааралгүй газрын асуудлыг хөндөж нийгмийг талцуулж байгаа нь зохисгүй юм гэв.

ИЗНН-ын дарга Б.Батбаатар хэлэхдээ: "Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр ИЗНН тодорхой байр суурийг илэрхийлж байгаа. "ИЗНН шударга ёс, эрх чөлөө, байгаль орчин, иргэдийнхээ сайн сайхны төлөө ажиллаж ирсэн. ИЗНН авлигын эсрэг хуулийг анхлан санаачилсан. Өнөөдөр авлигыг арилгах, авлигатай тэмцэх ажлыг иргэд олон нийт ойлгож, дэмжиж, тэмцэж байна. ИЗНН байгаль орчин ногоон хөгжлийн бодлогыг Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн яам болгож, Засгийн газрын үндсэн чиглэлийн яам болгож байсан. ИЗНН саяхан хуралдаж, дүрмэндээ өөрчлөлт шинэчлэлт хийсэн. ИЗНН өмнө нь ч, одоо ч хулгайчгүй нам байсаар ирсэн. ИЗНН аль ч цаг үед олон түмний нам байх бөгөөд ард түмний тайз байх болно. Эх орноо гэсэн сэтгэлтэй иргэн бүрийг энэ тайзан дээр гарч ирж оролцохыг уриалж байна гэв.

ИЗНН: "Цөлжилтийн эсрэг тэмцэх арга зам, инновацийг нэвтрүүлэх нь" эрдэм шинжилгээний Бага хурал зохион байгуулав

"Цөлжилтийн эсрэг тэмцэх арга зам, инновацийг нэвтрүүлэх нь" эрдэм шинжилгээний Бага хурал 2022 оны есдүгээр сарын 09-ний өдөр болов.

Хурлыг ИЗНН-ын ногоон хөгжлийн бодлогыг дэмжиж "Хил хязгааргүй нэг дэлхий" ТББ-аас санаачилж, мэргэжлийн харьяа байгууллагууд болох НЭМҮТ, МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэн, ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэн, Иргэний Зориг Ногоон хөгжил ТББ, Эко шийдэл ТББ, Судалгааны онлайн сэтгүүл гэсэн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

Монгол Улсын нийт газар нутгийн 76.8 хувь нь их бага хэмжээгээр цөлжилтэд өртсөн байгаа. Цөлжилтийн асуудал нь зөвхөн Монгол орны өмнө тулгамдсан асуудал биш юм. Дэлхийн бүх улс орнуудад хөрсний доройтол, цөлжилт их бага хэмжээгээр бий болсон бөгөөд тус бүртээ цөлжилттэй тэмцэх арга замыг хайсаар байна. Иймээс салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, цөлжилтийн талаарх ойлголтоо нэгтгэх, цөлжилтийн эсрэг шинж, шинэлэг арга туршлагыг судлах зорилгоор "Цөлжилтийн эсрэг тэмцэх арга зам, инновацийг нэвтрүүлэх нь" эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж байна гэж зохион байгуулагч Б.Батбаатар хэлсэн юм.

Бага хурлаар цөлжилтийн өнөөгийн бодит нөхцөл байдал, шалтгаан хийгээд үр дагавар байгаль экологи, эдийн засаг, нийгэм болоод хүний эрүүл мэнд, аж байдалд үзүүлж буй нөлөө, цөлжилттэй тэмцэх арга зам, туршлагын талаар олон салбарын төлөөлөл болох мэргэжлийн судлаачдын шинжлэх ухааны үндэстэй, бодит судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг хэлэлцэж үр дүнтэй шийдэл, инновацийг нэвтрүүлэх талаар нэгдсэн дүгнэлтэд хүрсэн бөгөөд эмхэтгэл гаргасан юм.

ИЗНН-д зөвлөхүүдийн баг ажиллаж байна

ИЗНН шинэчлэлийн бодлогынхоо хүрээнд Намын даргын дэргэд зөвлөх баг ажиллуулж байна. ИЗНН-ын дарга Б.Батбаатарын ахлах зөвлөхөөр эдийн засгийн ухааны доктор, дэд профессор Т.Бат-Эрдэнэ, эдийн засгийн бодлого хариуцсан зөвлөхөөр доктор Д.Амгалан, Соёл спортын бодлого хариуцсан зөвлөхөөр Монгол Улсын гавьяат дасгалжуулагч С.Ган-Эрдэнэ, Боловсрол, нийгмийн

хөгжлийн бодлого хариуцсан зөвлөхөөр доктор С.Эрдэнэчимэг, Жендерийн асуудал хариуцсан зөвлөхөөр Д.Уранцэцэг нар тус тус ажиллаж байна.

Салбар хариуцсан чиг үүргийн дагуу байгуулагдсан эдгээр зөвлөх баг ажилласнаар улс орны нийгэм, эдийн засаг, хөгжлийн стратегийг тодорхойлох ИЗНН-ын үндсэн бодлогод ач холбогдолтой байх юм гэж үзэж байна.

ТҮҮХЭН ОН ЖИЛҮҮД

Иргэний Зориг Ногоон нам үүсэн байгуулагдсан 24 жилийн хугацаанд парламентад 16 жил тасралтгүй төлөөлөлтэй ажиллаж буй Монголын улс төрийн ууган хүчин юм. Анх 2000 оны гуравдугаар сарын 09-ний өдөр С.Оюун тэргүүтэй хүмүүс бие даасан шинэ нам үүсгэн байгуулж, Монголын 24 дэх улс төрийн нам гал голомтоо бадраан даргаар нь С.Оюуныг сонгожээ. УИХ-ын 2000 оны сонгуульд ИЗН "Иргэний Зориг-Ногоон Нам" нэртэй эвсэл байгуулж, нийт 76 тойрогт 76 нэр дэвшүүлэн оролцож байв. Ингээд Дорнод аймгийн 17 дугаар тойргоос С.Оюун сонгогдож, парламентад суудалтай нам болсон. Үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн Иргэний Зориг нам гуравдагч хүчний орон зайг бий болгохын төлөө ажиллаж эхэлсэн. ИЗН парламентад суудалтай намын хувьд 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд АИХ депутат асан, академич, зохиолч Л.Дашнямын нэрийг дэвшүүлэн оролцсон. 2002 онд ИЗН, БНН-тай нэгдэж, намаа ИЗ-БНН гэж нэрлэжээ. Улмаар 2004 оныг дуустал "АН, ИЗ-БНН" нь Монголын ардчилсан хүчнийг нэгтгэн нягтруулах эрхэм зорилгоор УИХ-ын ээлжит болон ээлжит бус сонгууль, Орон нутгийн сонгуульд хамтран оролцох "Түншлэлийн гэрээ" байгуулж, АН-ын дарга Д.Дорлигжив, ИЗ-БНН-ын тэргүүн С.Оюун нар гарын үсэг зурж байв.

2005 онд ИЗ-БНН дүрмэндээ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжин бүх шатны сонгуульд нэр дэвших, намын удирдах бүтэц болох ҮХ, УТЗ-ийн бүтцийн 30-аас доошгүй хувийг эмэгтэйчүүдийн төлөөлөл байхаар оруулж, УИХ-ын сонгуулийн хуулийн төсөлд саналаа оруулсан нь манай улсад улс төрийн намуудаас анх удаа эмэгтэйчүүдийг дэмжсэн шийдвэр байсан юм.

2007 онд ХБНГУ-ын Гамбург хотноо болсон дэлхийн Либерал ардчилсан намуудын холбооны хурлаар ИЗН жинхэнэ гишүүнээр элссэн. Энэ холбоонд элссэнээр Монгол Улс дэлхийн улс төрийн гурван гол баганад өөрийн төлөөлөлтэй болж чадсан юм.

2007 онд Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр УИХ-ын гишүүн, ИЗН-ын дарга С.Оюунд хамтран ажиллах тухай санал ирүүлж, хамтарсан Засгийн газрыг байгуулж байв. Ингээд ИЗН С.Баярын Засгийн газарт Гадаад хэргийн болон Хүнс, Хөдөө аж ахуйн яамыг толгойлон ажилласан. 2008 онд Монголын Эв Нэгдлийн нам ИЗН-тай нэгдэж байжээ.

ИЗН нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 он болон 2013 оны сонгуульд парламентын намын хувьд АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж буюу ардчилсан ерөнхийлөгчийг дэмжин оролцож байв.

Тус нам 2011 онд Ногоон намтай нэгдсэн нь одоогийн Иргэний Зориг Ногоон намын

ИЗНН-ЫН ТҮҮХ, ОДОО, ИРЭЭДҮЙ



үүсэл байв. Энэ үед ИЗ-НН-д Монголын Хүний төлөө нам нэгдэн оров.

2012 оны нэгдүгээр сарын 28-нд ИЗН VIII Их хурлаа хийж, намын нэрээ "Иргэний Зориг Ногоон нам" хэмээн өөрчилж намын дүрмэндээ гурван даргатай байхаар өөрчлөлт оруулсан. ИЗНН-ын даргаар Д.Энхбат, С.Оюун, С.Дэмбэрэл нарыг сонгосон. ИЗНН нь 2012 онд УИХ-ын болон Орон нутгийн сонгуульд амжилттай оролцож 5.7 хувийн санал авч УИХ-д 2 суудалтай, НИТХ-д 1, аймаг, дүүргийн ИТХ-д 10 гаруй суудалтай болж байв. Улмаар сонгуулийн үр дүнд байгуулагдсан "Шинэчлэлийн засгийн газарт хамтран ажиллаж, БОНХЯ-ыг ерөнхий чиг үүргийн яам болгох санаачилгыг гаргаж, тус яамыг удирдан ажилласан билээ.

Парламентад суудалтай ИЗНН-ын санаачилгаар 2014 онд Монгол Улсын Ногоон хөгжлийн үзэл баримтлалыг УИХ-аар анх удаа хэлэлцүүлэн батлуулсан нь Монгол Улсын ногоон хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан. ИЗНН-ын дарга С.Оюун НҮБ-ын Байгаль орчны ассамблейн чуулганы ерөнхийлөгчөөр сонгогдож, Азийн Либерал, Ардчилсан Зөвлөл (CALD)-ийг удирдах эрхийг авч, АЛАЗ-ийн даргаар С.Оюун сонгогдов.

2015 онд ИЗНН нь 15 жилийн ойгоо тэмдэглэж, Намын IX их хурлаар 3 даргатай буюу С.Оюун, С.Дэмбэрэл, Ц.Ганхуяг нар намын даргаар сонгогдсон. Улмаар 2018 онд Үндэсний Хорооны хурлаар намын дүрмэнд өөрчлөлт орж, нам нэг даргатай болж, намын даргаар Ц.Ганхуяг үлдэв.

Ц.Ганхуяг даргатай ИЗНН нь 2020 онд УИХ-ын ээлжит сонгуульд МАХН, Монголын Уламжлалын Нэгдсэн намтай "Та бидний эвсэл" байгуулж оролцлоо. Энэхүү "Та бидний эвсэл"-ээс нэр дэвшсэн С.Ганбаатар олонхийн санал авч ялалт байгуулж, УИХ-д нэг суудалтай болсон.

ИЗНН - ОДОО БА ИРЭЭДҮЙ

ИЗНН нь түүхэн бүхий л он цаг үед улс төрийн томоохон акц, хөдөлгөөн өрнүүлж, нийгэм эдийн засгийг шинэчлэлд хувь нэмрээ оруулж ирсэнтэй холбоотойгоор бусад намуудтай нэгдэн нийлэх замаар улс төрийн үйл ажиллагаагаа идэвхжүүлж байсан үе бий. ИЗНН нь анх байгуулагдсан цагаасаа эхлэн парламентад тасралтгүй 16 жил төлөөлөлтэй ажилласан цорын ганц гуравдагч хүчин гэгддэг. Тус нам Засгийн газарт Хүнс, хөдөө аж ахуй, Байгаль орчин, Гадаад харилцааны сайдын албыг тус, тус хашиж байсан боловсон хүчинтэй нам юм.

2022 оноос намын үйл ажиллагаандаа шинэчлэлт хийж болсон ИЗНН-ын Үндэсний хороо 2023 оны зургадугаар сард хуралдаж, намын дүрмэндээ нэмэлт, өөрчлөлт оруулж, намын удирдлагаа шинэчлэн өөрчилсөн. Уг хурлаар ИЗНН-ын дарга Ц.Ганхуяг өөрийн хүсэлтээр ажлаа өгч байгаа тул дэд даргаар ажиллаж байсан УИХ-ын гишүүн асан Б.Батбаатарыг нэр дэвшүүлж, Үндэсний хорооны хурлаар гишүүдийн дунд явуулсан санал хураалтаар ИЗНН-ын даргаар сонгосон юм.

ИЗНН-ын дарга Б.Батбаатар нь дүүрэг, нийслэлийн хэмжээнд иргэдээ төлөөлж ажиллаж байсан, УИХ-ын гишүүнээр ажиллахдаа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар томилогдож байсан туршлагатай улстөрч.

Түүх арвин тус нам нь байгуулагдсан цагаасаа парламент, Засгийн газрын түвшинд төлөөлөлтэйгөөр төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн туршлага бүхий улс төрийн хүчин юм. Тухайлбал, ИЗНН-ын даргаар ажилласан С.Оюун гэхэд УИХ-д гурав сонгогдож, Гадаад хэргийн болон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдаар тус, тус ажиллаж байсан бол мөн даргаар ажиллаж байсан Ц.Ганхуяг ч УИХ, Засгийн газрын түвшинд ажиллаж байсан

“

ИЗНН НЬ МОНГОЛ УЛСЫНХАА ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТӨЛӨӨ ИДЭВХ САНААЧИЛГАТАЙ АЖИЛЛАЖ, ОЛОН ТҮМНИЙ ДЭМЖЛЭГ, ИТГЭЛИЙГ ХЭЗЭЭ Ч АЛДААГҮЙ УЛС ТӨРИЙН ХҮЧИН ЮМ.

“

туршлагатай юм.

Монголын парламентад ажилласан, хүчирхэг улстөрч ИЗНН-ын анхны дарга С.Оюун эдүгээ НҮБ-ын харьяа Ази, Номхон далайн цөлжилтийн эсрэг байгууллагад ажиллаж дэлхийн хүн болж монголчуудын бахархлыг төрүүлж байгаа.

Түүхэн он цагийн үед ИЗНН нь жендерийн тэгш байдлыг хангах тал дээр Монголд хамгийн анх санаачилга гарган ажиллаж байсны хувьд улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог идэвхжүүлэн дэмжих, парламентад эзлэх эмэгтэйчүүдийн тоо нэмэгдүүлэх, жендерийн тэгш байдлыг хангахад хамгийн их санаачилгатай ажилласаар байна.

Санжаасүрэнгийн Зориг агсны үзэл санааг тээж яваа цор ганц нам болох ИЗНН нь 24 жилдээ ногоон хөгжлийн үзэл баримтлалаасаа хэзээ ч ухралгүй, Монгол Улсад ардчилал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сэргээхийн төлөө цаг үе бүрд шинэчлэн хөгжиж ирлээ. УИХ-д хэдэнтээ суудал авч, улс орныхоо хөгжилд дуу хоолойгоо хүргэж, улс төр нийгмийн үйл хэрэгт үзэл санаагаа хүргэж ирсэн тус нам цаг үедээ нийцүүлэн хөгжлийн бодлогоо шинэчлэн, хөгжсөөр байна. Тус нам нээлттэй, намын гишүүдийнхээ оролцоог

нэмэгдүүлэн, олон нийтийн оролцоог идэвхжүүлэн дэмжих бодлогыг хэрэгжүүлж байна.

ИЗНН нь Х их хурлаараа эдийн засаг, байгаль орчинд ээлтэй нийгмийг бий болгох "Хөгжилд хүрэх ногоон зам" гэсэн алсын хараан дор нэгдэж байна гэдгээ зарласан. ИЗНН Х их хурлаараа "Тогтвортой шударга, хүртээмжтэй ирээдүйн төлөө" тунхаг бичиг гаргасан. Уг тунхаг бичигт байгаль орчны хөгжил, эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжил, гадаад хамтын ажиллагаа гэсэн цогц байдлаар хөгжлийг бий болгох хөгжлийн бодлогыг тусгажээ.

Улс орнуудын хооронд хил хязгаар байдаг ч, эх ногоон байгаль дэлхийгээ хайрлахад хил хязгаар үгүй юм. ИЗНН нь ногоон хөгжлийн бодлого дээр Монгол Улс цаг үетэйгээ нийлсэн шинэчилсэн бодлогоор хөгжих ёстой гэж үзэж, ногоон соёл иргэншлийг бий болгох санал, санаачилгыг дэвшүүлээд байна. Манай улс дэлхийд ногоон соёл иргэншлийг хэдэн мянган жил тасралтгүй тээж ирсний хувьд ногоон соёл иргэншлийн санаачилгаар дэлхий дахинд түүчээлэх боломж бий. Ингэж чадвал Монгол Улс хөгжилд хүрэхэд нэлээд том түлхэц болох боломжтой. Иймд ногоон соёл иргэншлийн хөгжлийг төрийн бодлого болгох ёстой гэж үзэж байгаа юм.

Хөгжил бол хүний сайн сайхан, аз жаргалтай амьдралын төлөө чиглэгддэг. Нийгмийн хөгжил дэвшлийг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэггүй, харин нийгмийнхээ гишүүн бүрийг хэр зэрэг өөдрөг болгож чадсанаар хэмжигдэнэ. Иймээс нийгэм дэх тэгш бус байдлыг арилгахын төлөө ИЗНН ажиллаж байна. ИЗНН ард түмний индэр байх болно гэдгээ зарласан.

ИЗНН нь түүхэн он цаг хугацааны үед, өдгөө ч Монгол Улсынхаа хөгжил дэвшлийн төлөө идэвх санаачилгатай ажиллаж, олон түмний дэмжлэг, итгэлийг хэзээ ч алдаагүй улс төрийн хүчин юм.

- ДҮҮРГИЙН НАМЫН ХОРООНЫ ДАРГА НАР ЯРЬЖ БАЙНА -

ИЗНН-ын Хан-Уул дүүргийн Намын хорооны дарга Я.ПҮРЭВГАРЬД:



-Хан-Уул дүүргийн ИЗНН-ын хорооны хурал саяхан боллоо. Хурлаар хэлэлцсэн асуудал болон үр дүнгийн талаар мэдээлэл өгөхгүй юу?

-ИЗНН-ын Их хурлаар дүрмийн өөрчлөлт хийсэн. Үүнтэй холбоотойгоор намын анхан, дунд шатны байгууллагыг

өөрчилсэн. Шинэчилсэн дүрэмтэйгээ уялдуулж хурал хийх, нийслэл, дүүрэг, Үндэсний хороодынхоо гишүүдийг сонгох үйл ажиллагаа явагдсан. Дүүргийн намын хорооны хурал дараа дараачийн үйл ажиллагааны эхлэл нь болсон гэсэн үг. Энэ нь шинэчлэгдсэн дүрмийн дагуу явуулж байгаа ИЗНН-ын үйл ажиллагааны эхлэл юм. Намын гишүүнчлэлийг анхаарч ажиллаж байна.

-Цаашид ямар бодлого барьж ажиллах вэ?

-Энэ намыг анх 2000 онд байгуулагдахад би анхны гишүүнээр байсан. Өнгөрсөн хугацаанд намынхаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн. Нам саяхнаас бүтэц, зохион байгуулалтаа шинэчилж, хөгжлийн шинэ бодлого гаргаж байгаа учир намынхаа бодлогыг дэмжиж ажиллана.

ИЗНН-ын Баянзүрх дүүргийн Намын хорооны дарга Н.ЭРХЭМБАЯР:



-Баянзүрх дүүргийн ИЗНН-ын хорооны хурлаар хэлэлцсэн гол асуудлыг тоймлон хэлбэл?

-БЗД-ийн намын хорооны хурал боллоо. Шинэ дүрмийнхээ дагуу БЗД-ийн ИЗНН-ын бүх гишүүдээ цуглуулаад намын хороонд бүртгэж, намын хороогоо бүрдүүлэх ажил хийсэн. Намын дүрмийн шинэчлэлтэй холбоотойгоор намын гишүүдэд мэдээлэл өгөх ажлыг зохион байгууллаа. Орсон өөрчлөлтүүд, бүтэц зохион байгуулалтын талаар зөвлөгөө мэдээллийг намын даргын ахлах зөвлөх Т.Бат-Эрдэнэ хүргэсэн. Нийтдээ 40 орчим хүн ирснээс 22 хүнийг намын хороондоо бүртгэсэн. Идэвхтэй гишүүд, шинээр элссэн гишүүд, үе үеийн төлөөлөл оролцсон хурал болж өндөрлөсөн. Манай идэвхтэй гишүүд дэмжигчдээс гадна шинээр намд элсэх хүсэлтэй 26 хүн бүртгүүлсэн.

-Шинээр элссэн гишүүд ямар учраас ИЗНН-ыг сонгосон бол?

-Намын бодлого чиглэл тодорхойлогдоод, бүтэц, дүрмийн өөрчлөлт

хийсэн талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээгээр авсан байна. Бид ч гэсэн мэдээлэл тарааж байгаа. Энэ мэдээллийн дагуу шинэ хүмүүс ирсэн. 20 настай, GenZ үеийн төлөөлөл ирээд намд элсэж, дуу хоолойгоо өргөө, үзэл санаагаа илэрхийлье гэж нэгдсэн. Бид маш талархалтай хүлээж авсан.

-Цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил юу байна?

-Гишүүд дэмжигчдээ идэвхтэй болгох, тэднийг мэдээллээр хангах, ИЗНН-ын төлөө гэсэн итгэл, сэтгэл, зүтгэлтэй хүмүүсээр гэр бүлээ нэмэх зорилготой байна. 5000-6000 байнгын гишүүнтэй болох зорилго тавьсан байгаа. Эдгээр гишүүдээс бид хороогоо төлөөлөх хүмүүсийг сонгон шалгаруулж, гишүүд маань улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулах чиглэлийг барьж байна.

-Намын үзэл баримтлал, үйл ажиллагаатай холбоотой таны байр суурийг сонирхъя?

-Манай нам ардчилсан үзэл санаатай, ногоон хөгжил, ногоон эдийн засгийг эрхэмлэдэг. Би өөрөө барилга, үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарт ажилладаг болохоор ногоон эдийн засгийг хөгжүүлэх, эрх чөлөөтэй, ардчилсан, тэгш эрхтэй байх хүсэл сонирхолтой. Ардчилсан, шударга, бизнес хийхэд ямар нэгэн байдлаар хэн нэгэнд давуу тал олгодоггүй, бүгд тэгш, шударга өрсөлддөг баймаар байна. Хог хаягдалгүй үйлдвэрлэл, ногоон эдийн засаг, ногоон тойрог, шилжилт рүү бид явмаар байна.

ИЗНН-ын Чингэлтэй дүүргийн Намын хорооны дарга С.ХАН-УУЛ:



-Дүүргийн намын хороо ямар асуудлаар хуралдав?

-Чингэлтэй дүүргийн намын хорооны хурал амжилттай зохион байгуулагдлаа. ИЗНН-ын дүрмэнд өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн тухай танилцууллаа. Манай нам бүтэц зохион байгуулалтын шинэчлэлт хийж, бүхий л талаар үйл ажиллагаагаа идэвхжүүлэх болсон. Нийслэлийн

дүүргүүд намын хорооныхоо хурлаа бүгд хийж байгаа. Энэ үеэр намын гишүүдийнхээ бүртгэлийг сайжруулж, бас намд шинээр гишүүд элсч орцгоож байна. Чингэлтэй дүүргийн хувьд ИЗНН-ын гишүүд, дэмжигч олонтой.

-ИЗНН бусад улс төрийн намуудаас ялгарах гол онцлог юу вэ?

-Монголын ууган улс төрийн хүчин ИЗНН нь өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа тогтмол явуулж ирсэн байдаг. Нэр цэвэр нам. Ногоон хөгжлийн бодлогод Монгол Улсад дорвитой хувь нэмэр оруулж ирсэн. Нийгэм эдийн засгийн хэрэгтэй бодлогуудыг гаргаж, төрд хэрэгжүүлж байсан.

Манай намын онцлог нь намын гишүүд, дэмжигчдийнхээ итгэл үнэмшил дээр тогтдог, гишүүн суурьтай нам. Намын дарга солигдсонтой холбоотойгоор ИЗНН шинэчлэлийн олон сайн бодлогууд гаргаж байгаа.

ИЗНН-ын Сонгинохайрхан дүүргийн Намын хорооны дарга Г.Роза:



-Дүүргийн намын хорооны хурлаар ямар асуудал хэлэлцэв?

-Сонгинохайрхан дүүргийн намын хорооны хурал арванхоёрдугаар сарын 13-нд хуралдлаа. Зохион байгуулалтын асуудал хэлэлцлээ. Дарга, дэд дарга сонгосон. Дэд даргаар Д.Даваадорж сонгогдсон. Дүрмийн хороогоо сонгосон. Үндсэн гишүүдээр 64 хүн сонгогджээ. Намын Үндэсний хороо, тэргүүлэгчид, Нийслэлийн тэргүүлэгчид, дүүргийн тэргүүлэгчидийг бас сонгосон. Бид төв намаас гаргасан бодлого шийдвэрийг барьж ажиллаж байна.

-Та ИЗНН-ын анхны гишүүдийн нэг. ИЗНН өнгөрсөн 24 жилийн хугацаанд

хэр шинэчлэгдэж хөгжиж байна вэ?

-Би 2000 онд намын гишүүн болж байв. Манай нам өнгөрсөн хугацаанд намынхаа үндсэн бодлого болох эко ногоон хөгжлийн бодлогоосоо хазайлгүй тасралтгүй энэ бодлогынхоо хүрээнд олон ажлууд хийж иржээ.

-Сонгинохайрхан дүүргийн намын онцлог юу байна вэ?

-Манай Сонгинохайрхан дүүргээс УИХ-д хоёр ч удаа гишүүн гарч байсан. Манай нам, дүүрэг өнгөрсөн хугацаанд улс төрд маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн. Хамгийн сүүлд гэхэд ИЗНН "Та бидний эвсэл"-ээр сонгуульд оролцож УИХ-д нэг суудал авсан. Парламентад олон удаа суудалтай явж ирсэн нам. Мөн орон нутгийн сонгуулиудад ч амжилттай оролцож ирсэн.

Намын гишүүдийн хувьд өнгөрсөн хугацаанд одоо ч тэр намдаа маш идэвхтэй оролцоотой байдаг. 2023 оноос намын шинэ даргатай болж, бүтэц зохион байгуулалтууд хийгдсэнээр үйл ажиллагаа маань улам идэвхжиж, намын гишүүнчлэл улам сэргэж байна. Намд шинээр залуучууд их орж ирж байна.

ИЗНН-ын Баянгол дүүргийн Намын хорооны дарга Г.УУГАНХҮҮ



-Намын хорооны хурлын талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Баянгол дүүргийн ИЗНН-ын хороо нь Нийслэлийн Намын Хорооны даргын 06 тоот тушаалын дагуу 01 дүгээр сарын 15-нд хурлаа хийлээ. Манай үндсэн дүрмийн дагуу бол дүүргийн намын хорооны хурлыг дүүргийн намын дарга зарлаж хуралдуулах ёстой байдаг. Гэхдээ дарга өвдсөн, удаан хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай болсон, мөн нэг дэд дарга чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн зэрэгтэй холбогдуулан даргаа шинээр сонгох, шинэ гишүүдээ батлах, намын дүрмэнд өөрчлөлт орсонтой холбогдуулан дүүргийн намын хорооны сонгуульд гишүүдийг чөлөөлөх, шинээр

сонгох, алдаа оноо, амжилтаа ярилцан хэлэлцэж, асуудлуудаа шийдвэрлэн хуралдлаа.

-ИЗНН-ын үзэл баримтлал, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар таны байр суурь?

-Манай намын үйл ажиллагааг идэвхтэй бус байна гэж хэлэх хүмүүс байдаг ч хийж буй ажлуудынхаа мэдээллийг тэр болгон өгч чадаагүй байсан нь бас бидний буруу байгаа байх аа. Манай нам хүний эрх, эрх чөлөө, зөв тогтолцоо, шударга ёсыг дээдэлсэн, үндэсний өв уламжлалт сэтгэлгээ, хандлагыг эрхэмлэн хөгжүүлэн дэмжигч, ногоон хөгжлийг тэргүүлэх бодлогоо болгосон, экологийн чиг баримжаатай, байгаль дэлхий, нутаг усаа хайрлан хамгаалах, дэлхийн ногоон чиг хандлагын гүүр нь байж, тогтвортой хөгжлийн замд улс орноо хөтөлж Монголдоо сайхан амьдрах боломжийг бүрдүүлэх үзэл баримтлалтай. Монголчууд бид өөрсдийнхөө өв соёл, үнэт зүйлс, бусдаас давуу байдлаа анзаардаггүй. Бид оюун санаа, ёс уламжлалын хувьд хүн төрөлхтөн бишрэм соёлтой ард түмэн. Хүн бүр оролцоотой байвал улс орон хөгжинө гэдэг үгс санаанд үргэлж явдаг.

ИЗНН-ын Сүхбаатар дүүргийн Намын хорооны дарга Ч.МӨНХЖАРГАЛ:



-Дүүргийн намын хорооны хурлын талаар мэдээлэл өгөхгүй юу?

-2024 оны 01 дүгээр сарын 17-нд Сүхбаатар дүүргийн намын хорооны хурал боллоо. Хурлаар бид дүүргийн намын хороодыг идэвхжүүлэх, 2024 оны сонгуульд хэрхэн оролцох, шинэ залуу гишүүдийг хэрхэн гишүүнээр элсүүлэх талаар ярилцсан. Миний бие дүүргийн намын хорооны даргаар сонгогдоод дүүргийн намын байраа тохижуулах

ажилтай л явж байна. Цаашид залуу үеийн төлөөллийг намдаа элсүүлж, би өөрөө залуу хүний төлөөлөл учраас энэ талыг нэлээн барьж ажиллаж гэж бодож байна. Гэхдээ ахмад гишүүдийг дэмжихгүй гэж байгаа юм биш. Намын их хурлаар би анх намын гишүүн болж байсан. Ахмад гишүүд маань үзэл баримтлалдаа тууштай, үнэнч байдаг юм билээ. Тийм учраас цус сэлбээ гэдэг үүднээс залуу гишүүдийг элсүүлж ажиллах бодолтой байгаа.

-ИЗНН-ын үзэл баримтлал, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар таны байр суурь?

-Миний байр суурь намын үзэл баримтлалтай нийлж байсан учраас би энэ намыг сонгож орж ирсэн. Үзэл санааны хувьд, нийгмийн тэгш ардчилал, ногоон хөгжил гэдэг чухал. Гол нь бид үр хүүхдүүддээ юу үлдээх вэ, хүрээлэн буй орчноо ногоон чигээр нь үлдээж байвал бидний хийж байгаа том үйл хэрэг гэж үзэж байгаа.

Р.БАТБОЛД: ИЗНН НАМЫН ГИШҮҮДИЙНХЭЭ ОРОЛЦООГ ХАНГАХ АЖЛУУД ХИЙЖ БАЙНА

ИЗНН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Р.Батболдтой ярилцлаа.

-ИЗНН-ын удирдлагын бүтцэд нэлээн өөрчлөлт орж байна. Танай нам ямар ажлууд хийж байна вэ?

-ИЗНН шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж байна. Сүүлийн долоон жилийн хугацаанд намын үйл ажиллагаа хумигдмал байдалтай, нийгмийн идэвх тааруу байсан нь үнэн. Гэсэн хэдий ч ИЗНН-ын дэмжигч, намын гишүүд итгэл үнэмшилдээ үнэнч хэвээр явж ирсэн. Өнгөрсөн оны зургадугаар сард намын дарга удирдлага солигдон шинэчлэгдэж Намын шинэ даргыг Х Их хурлаараа баталгаажуулсан. Улс төрийн намын тухай хууль шинээр мөрдөгдөж эхлэхтэй холбоотойгоор өнгөрсөн оны арванхоёрдугаар сард Үндэсний хорооны хурал хуралдаж, уг хуульд нийцүүлэн Намын үндсэн дүрмэндээ өөрчлөлт оруулсан. Одоо шинэ дүрмийн дагуу анхан болон дунд шатны намын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж байна. Намын гишүүдийн шинэчилсэн бүртгэл хийгдэж байна. Нийслэлийн дүүргүүдийн намын хорооны хурлууд хийгдэж, намын хорооны гишүүд, намын сонгуульт гишүүд болох Үндэсний хорооны гишүүн, Улс төрийн зөвлөлийн гишүүдээ сонгох сонголтууд хийгдэж байна. Зургаан дүүргийн намын хороо хуралдаад явж байна. Үндсэндээ Нийслэлийн анхан болон дунд шатны намын байгууллагуудын үйл ажиллагаа жигдэрч эхэлсэн. Одоо хөдөө орон нутгийн салбар нэгжүүд рүүгээ анхаарч ажиллана. Улс орон даяар намынхаа гишүүдийг идэвхжүүлэх, бүрэн хамруулах талаар тодорхой ажлууд хийхээр төлөвлөөд ажиллаж байна. Энэ онд болох УИХ болон орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдээ сонгож гаргах чадавхи нөөц бололцоо бидэнд байгаа. Манай нам дарга төвтэй бодлого баримтлахгүй. Тиймээс Нийслэл, орон нутаг руу ажиллаж, намын гишүүдээсээ саналыг нь сонсож, намын гишүүдийн үзэл бодол, шийдвэрийг нэгтгэнэ.

-Намын дүрмэнд гол ямар өөрчлөлтүүд оров?

-Намын дүрэмд орсон гол өөрчлөлт нь намын бүтцийн хувьд маш ойлгомжтой, уян хатан, шийдвэрийг богино хугацаанд гаргах чадвартай болж байгаа. Хуучин дүрэмд байсан бага хурал, бүгд



хурал, тэргүүлэгч гэх мэт нэр томьёо өөрчлөгдсөн.

ИЗНН-ын явуулж буй бодлого бол хуучин, шинэ аль ч намын гишүүдийг дүрэмд зааснаас бусад тохиолдолд гишүүнчлэлээс нь хөөх, гаргах тухай ярихгүй. Сонгуульт гишүүний татвараа төлөөгүй тохиолдолд дүрмийн дагуу тодорхой сонгуульт гишүүний үүргээс л чөлөөлөгдөх гэх мэт уян хатан байдлаар ажиллана.

-ИЗНН парламентад 16 жил тасралтгүй байсан нам. Ногоон хөгжлийн үзэл баримтлал бүхий ИЗНН бусад намаас ялгарах онцлог юу вэ. Нам шинэчлэгдэж чадаж байгаа юу?

-Бүх намууд нийгмийн сайн сайхны төлөө ажиллана гэж ярьдаг. Бодит байдал дээр өнөөдөр нийгэм ямар байгааг хараад үзье. Агаар, хөрсний бохирдол гээд эрүүл амьдрах нөхцөл улам хүндэрсээр байна. Төрийн хүнд суртал, авлига багассангүй. Иргэд хөдөлмөрлөөд зүтгээд байгаа хэрнээ өдрөөс өдөрт ядуурал руу гулсан орох боллоо. Сүүлийн найман жил гэхэд хүчээ нэгтгэсэн эрх баригчид, нэг нам ямар үр дүнд хүргэдгийг нийгэмд дэлгэгдэж буй хэргүүдээс харж болно. Наад захын жишээ гэхэд татвар төлөгчдийн мөнгөөр улайм цайм эвдэрхий хуучин авто-

бус оруулж ирчихээд ард түмэнд шинэ автобус гээд ичиж эмээхгүй мэлээд зогсч байсан. Түүнийгээ иргэдээр дэмжүүлэн яриулж чадаж байна гэдэг маань маш их зүйл бодох, өөрчлөх хэрэгтэй болсныг харуулж байна. Нэг нам дангаараа засаг барихад өнөөдөр хулгай, авлига багасав уу. Ард түмний амьдрал амьжиргаа хэр дээшлэв. Ардын нам, Ардчилсан намд ч хулгай байдгийг сүүлийн 30 жилээс харлаа. МАНАН бүлэглэл хүртэл бий болж байлаа. Хоёр нам хэн хэндээ барьцаалагдсан байдалтай явж ирлээ. Манай улс Үндсэн хуульдаа олон намын системтэй, парламентын засаглалтай улс байна гээд тусгачихсан. Гэтэл үндсэндээ ганц нам л засгийн эрхийг барьсаар ирлээ. Олон намын системтэй байх нь Төрд хяналт тавьж чадах, сөрөг хүчний үүргийг гүйцэтгэх, ил тод байдлыг нэмэгдүүлж олон талт бодлого хэрэгжихэд тустай юм. 24 жилийн түүхтэй ИЗНН-ын төлөөлөл парламентад 16 жил байхдаа муу нэрд холбогдож байсан түүх байдаггүй. ИЗНН ногоон хөгжлийн бодлогыг хамгийн анх дэвшүүлэн гаргаж, салбарын яамыг үндсэн чиглэлийн яам болгож байсан. Эмэгтэйчүүд жендерийн асуудалд улс төрийн намуудаас санал оруулж байсан гэх мэт ИЗНН-д хийсэн ажил их бий. Хамгийн гол нь өнгөрсөн хугацаанд ИЗНН нэр цэвэр, ард түмний эрх ашгийн төлөө ажиллаж ирсэн байдаг. Одоо ч ИЗНН-ын удирдлагын багт дундаж ид насны, нэр цэвэр залуучууд хүч түрэн орж ирж байна. Бид төрийн ямарваа нэгэн хулгайтай нэр холбогдож байгаагүй. Төрд очоод дарга болчих юмсан гэсэн явцуу эрх ашиггүй. Нийгэмд эрүүл орчныг бүрдүүлэх, өнөөгийн тулгамдсан асуудалд бодлого гаргаж шийдвэрлэхийн төлөө ажиллаж байна.

-Ер нь удирдлагын багтаа эмэгтэйчүүдийн оролцоог хэр хангах вэ?

-ИЗНН Монголын улс төрийн намуудаас хамгийн анх 2005 онд намын дүрмэндээ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих тухай саналыг гаргаж, УИХ-ын сонгуулийн хуулийн төсөлд санал оруулж байсан түүхтэй. Бүх шатны сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, намын удирдлагын бүтэц Үндэсний хороо, Улс төрийн зөвлөлийн бүтцийн 30-аас доошгүй хувийг эмэгтэйчүүдийн төлөөлөл байх тухай саналыг ингэж анх оруулсан. Өнгөрсөн есдүгээр сард гэхэд ИЗНН-ын дэргэдэх

байгууллага эмэгтэйчүүд, залуучууд, ахмад, оюутны холбооны хурал зохион байгуулсан. Цаашид ч намын удирдлагын болоод анхан, дунд бүх шатанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, эмэгтэй манлайлагчдыг бүхий л талаар дэмжих, эмэгтэйчүүдийн улс төрийн индэр тайзыг гаргаж ажиллах болно.

-Одоогийн шинэчлэлийн үр дүнд нам хэр төлөвших бол. Олон нийт рүү чиглэсэн нийгэм, эдийн засгийн томоохон ямар бодлого барьж ажиллах вэ?

-Намын бодлого, дүрэм, бүтцэд өөрчлөлт оруулах, намын гишүүдийг чадавхжуулах гэх мэтээр дотоод үйл ажиллагаагаа шинэчилж байна. Олон нийт рүү нийгэм рүү чиглэсэн хөгжлийн бодлого гаргаж бүхий л талаар нам шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж байна. Залуучуудаар хүрээгээ тэлсэн. Манай нам төрд буй хулгайг таслан зогсоох, улс төр дэх мөнгөний нөлөөллийг багасгаж чадахуйц нэр цэвэр, боловсролтой, чадварлаг хүмүүсээр эгнээгээ тэлж байгаа. Намын гадаад харилцааны хүрээнд БНСУ-д саяхан албан томилолтоор ажиллахад олон хүн ИЗНН-ын үйл ажиллагааг дэмжиж байгаагаа хэлж, намын үйл ажиллагааг дэмжмээр байна гэдгээ илэрхийлж байсан. Ингээд хилийн чанадад намын гишүүд, дэмжигчийн клубууд байгуулагдахаар болсон. ИЗНН ард түмний нам учраас үнэт зүйл зарчмаа барьж, намын төлөө бус нийт монголчуудынхаа төлөө ажилладаг. Нам бол хэн нэгэн болон намын нэр барьсан бүлэг этгээдийн өмч биш. Манай нам дарга төвтэй явахгүй гэдгээ зарласан. Иргэд, гишүүд төвтэй ажиллана. ИЗНН ард түмний нам учраас олон нийтийн төлөөлөл болж ажиллана. ИЗНН үндсэн үзэл баримтлалын дагуу өдрөөс өдөрт хумигдаж буй ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын төлөө ажиллана. Үндэсний ухамсар, сэтгэлгээг хөгжүүлэн, хувийн өмч дээр суурилсан чадамжтай эдийн засгийг бий болгох замаар эх орондоо сайхан амьдрах боломжийг бий болгоно. Мэдээж манай намын тэргүүлэх гол бодлого болох байгаль эх дэлхийд ээлтэй ногоон хөгжил, ногоон соёл иргэншлийг өнөө цаг үед нийцүүлэн бүхий л үйл ажиллагаанд нэвтрүүлэхийн төлөө ажиллана.

Б.ОДМАА

• ГАДААД ХАРИЛЦАА:

ИЗНН-ын гишүүд, дэмжигчдийн клубүүд БНСУ-д байгуулагдлаа



Намын Их хурлаа хийж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн ИЗНН гадаад харилцаагаа ч өргөжүүлж байна.

Мөн хилийн чанад дахь монголчууд болон тус намын гишүүд, дэмжигчидтэйгээ уулзаж, бодлого, үйл ажиллагаагаа танилцууллаа. Энэ

удаа тус намын дарга Батын Батбаатар, дэд дарга Л.Ганхуяг, намын генсек Р.Батболд нар БНСУ-д ажиллаж, дэмжигч, гишүүдтэйгээ уулзалт зохион байгуулжээ. БНСУ дахь монголчууд тэднийг найрсаг хүлээн авч, мөн гишүүд дэмжигчдийн клубүүд байгуулагдав.

ИЗНН-ынхан Хятадад айлчлав

Иргэний Зориг Ногоон нам 2023 оны есдүгээр сард БНХАУ-д айлчилж, өмнөд хөрсний цөлийг ойжуулах, хотоо ногооруулах ногоон хөгжлийн бодлого, туршлагатай танилцлаа. ИЗНН нь Монголын улс төрийн хүчнүүдээс анх ногоон хөгжлийг ногоон бодлогын хэмжээнд гарган ирж, энэ чиглэлд дорвитой ажил хийж ирсэн. Тиймээс энэ удаа Хятадын Коммунист намын урилгаар тус намын 20 төлөөлөгч Хятад улсын ногоон хөгжлийн туршлагаас хуваалцаж буй юм. ИЗНН-ын гишүүд дэлхийд ногоон хөгжлөөр үлгэр жишээ болсон БНХАУ-ын ӨМӨЗО, Ордос, Бугат гэх мэт хэд хэдэн хотуудаар орж, ногоон хөгжлийн туршлагатай танилцав.



Сүүлийн жилүүдэд ӨМӨЗО жил бүр 12 сая м² (800 мянган га) цөлжсөн газрыг засаж, цөлжилттэй тэмцэх ажлын 40 гаран хувийг бие даан гүйцэтгэжээ. Энэ хүрээнд Өвөр Монголын бүс нутагт цөлжсөн, элсжсэн газрын талбайн хэмжээ хоёр дахин буурч, ойн талбай, ойн сангийн хэмжээ хоёр дахин нэмэгдсэн байна.

Хятадын долоо дахь том цөл болох Кубуки цөлийн зүүн

төгсгөл, ӨМӨЗО-ны Ордос хотын "Ингэн тал" цөлийг хориод жилийн өмнө "Үхлийн далай" хэмээн нэрийддэг байсан бол өнөөдөр Хятадын "4А" зэрэглэлийн цөлийн экологи, соёлын аялал жуулчлалын бүс болж чаджээ.

Иргэний Зориг Ногоон намын төлөөлөгчдийн аяллын үеэр тус улсын техник технологийн хөгжилтэй танилцсан юм.



ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

САЙН ЦАГИЙГ БИД АВЧИРНА

Иргэний Зориг Ногоон нам нь ардчилал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлсэн, байгаль дэлхий, нутаг усаа хайрлах үндэсний уламжлалт сэтгэлгээ, хандлагаа эрхэмлэн хөгжүүлэгч, хувийн өмчид суурилсан тогтвортой эдийн засаг, ногоон хөгжлийг тэргүүлэх бодлогоо болгон тууштай хэрэгжүүлэгч, нийгмийг шинэчлэгч нам юм.

Тус нам нь ардчилал, хүний эрх, чөлөөний үзэл санаанд тулгуурлан, экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн замд улс орноо хөтөлж, хүн бүр өөрийн хүсэл эрмэлзлэлээрээ, шударга хөдөлмөрийнхөө үрээр Монголдоо сайхан амьдрах боломжийг бүрдүүлнэ.

ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

ҮЙЛ ЯВДАЛ

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛЬ ГАРДУУЛАВ



Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажилласан хүмүүсийг Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагналаа.

Шагналыг ИЗНН-ындарга Б.Батбаатар тэргүүтэй намын удирдлагууд 2023 оны долдугаар сарын 10-ны өдөр гардуулан өгч, намын гишүүдээ баяр хүргэв. ИЗНН-ын гишүүдээс Монгол Улсын гавьяат цол тэмдгээр нэг хүн, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор хоёр, Алтан гадас одонгоор 13, Хөдөлмөрийн хүндэт медалиар 13 хүнийг шагнав. Энэ үеэр Ардын хувьсгалын 100 жилийн ойн медалийг 21 хүн, Боловсролын яамны хүндэт жууц бичгээр 6 хүнд тус тус гардуулав.

Мөн 2024 оны нэгдүгээр сарын 03-ны өдөр ажил үйлсээрээ манлайлсан ИЗНН-ын гишүүд, дэмжигчид Монгол Улсын төрийн хүндэт одон медалиар шагнагдав.



ХӨВСГӨЛ АЙМАГТ БЭСРЭГ НААДАМ-ЭКО АЯЛАЛ ХИЙВ



Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан ИЗНН-аас Хөвсгөл аймагт бэсрэг наадам 2023 оны долдугаар сарын 21-нээс 25-ны өдрүүдэд болж өнгөрлөө. Үндэсний бөх, хурдан морины уралдаан зохион байгуулж шалгарсан тэргүүн байруудыг байлж, гарын бэлэг гардуулж баяр хүргэлээ. Мөн олс таталт, шатрын тэмцээн хийв. Энэ үеэр аймаг, дүүрэг, нийслэлийн намын хорооны гишүүд урлагийн тоглолт, үзүүлбэр үзүүлж авьяас хүчээ сорьсон юм.

Ийнхүү ИЗНН-ыхан Хөвсгөл аймагт бэсрэг наадам хийж, байгальд ээлтэй эко аялал зохион байгуулав.



ШИНЭ ЖИЛ-2023



“ЦАСНЫ БАЯР” АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО

ИЗНН-ынхан “Цасны баяр-2023” хийлээ. Уг арга хэмжээнд Нийслэл, орон нутгийн намын хорооны гишүүд оролцож, хөл бөмбөг, олс таталт, сумо барилдах зэрэг спортын уралдаан тэмцээнийг зохион байгууллаа.